

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБАНЫ 2017 ОНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүрээнд

Завхан аймгийн 2017 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд урсгал төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгагдсан 89.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 306.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 336.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 6, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 549.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 нэр төрлийн нийт 1279.2 сая төгрөгийн 15 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 85.2 сая төгрөгөөр 2, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 305.0 сая төгрөгийн 5, орон нутгийн хөрөнгөөр 330.6 сая төгрөгийн 5, нийт 14 нэр төрлийн 1192.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагааг зохион байгуулан 86.5 сая төгрөгийн хэмнэлтийг гаргасан байна. Дээрх арга хэмжээний 21% буюу 3 төсөл арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Зохион байгуулсан төсөл арга хэмжээг хэрэгжсэн байдлаар нь ангилвал гэрээ байгуулсан 10, шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 4, захиалагчийн шийдвэрээр цуцлагдсан 1 байна.

1.2 Тухайн жилийн худалдан авах ажиллагаанд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаар:

Төлөвлөгөөнд тусгагдаагүй 54 нэр төрлийн 3992.4 сая төгрөгийн төсөв өртөг бүхий төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна. Үүнд: урсгал төсвийн хөрөнгөөр 1845.1 сая төгрөгийн 38, төсвийн хөрөнгөөр 420.7 сая төгрөгийн 3, орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр 119.8 сая төгрөгийн 4, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 161.2 сая төгрөгийн 5, бусад хөрөнгөөр 1236.1 сая төгрөгийн 3, өөрийн хөрөнгөөр 33.0 сая төгрөгийн 1, нийт 3815.9 сая төгрөгийн 54 арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 181.4 сая төгрөгийн хэмнэлт гарсан. Үүнийг хэрэгжсэн байдлаар нь ангилвал гэрээ байгуулсан 39, шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн 15 төсөл арга хэмжээ байна.

1.3 Эрх шилжиж ирсэн худалдан авах ажиллагааны талаар:

Эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгөөр 10489.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас 10263.5 сая төгрөгөөр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 226.3 сая төгрөгийн хэмнэлтийг гаргасан бөгөөд 100% гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны алба нь 2017 онд нийт 15272.1 сая төгрөгийн 78 төсөл арга хэмжээг хуулийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг тендер хүчинтэй байх хугацаанд нь өгч ажиллаа. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг Аймгийн Засаг даргын захирамжаар 5, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж, ИТХ-ЫН шийдвэрээр томилогдсон иргэний төлөөлөл, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл, Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох хэлтэс ангенлагуудыг оролцуулан ажилласан. Үнэлгээний хороо нь Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 68 дугаар тогтоолын дагуу худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн дагуу тендерийг зохион байгуулсан.

2.1 Цахим тендер шалгаруулалт

Худалдан авах ажиллагааны программ шинэчлэгдэхтэй холбогдуулан 2017 оны эхний 4-н сард Цахим худалдан авах ажиллагааг түр зогсоосон. 2017 оны 05 дугаар сарын 15-наас эхлэн шинэчилсэн цахим программ ашиглалтанд орсон. 2017 онд Худалдан авах ажиллагааны албаны төлөвлөгөөнд тусгагдсан 21 ажлаас 18 ажлыг 2017 оны 4 дүгээр

сараас өмнө зарлаж тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. 2017 оны 05 дугаар сараас хойш төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд болон эрх шилжиж ирсэн: Завхан аймгийн Ургамал сумын хойд урд модон гүүр барих, Эрдэнэхайрхан сумын Цэцэрлэгийн барилгын засварын ажил, Цагаанхайрхан сумын цэцэрлэгийн барилгын усан хангамж, Алдархаан сумын Алаг ууланд G-Mobile -ийн антенн суурилуулах ажил, Идэр сумын Идэрийн голын гүүр барих тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлаж зохион байгуулсан. 2018 оноос худалдан авах ажиллагааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

3. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдал:

2017 онд Худалдан авах ажиллагааны албанаас зохион байгуулсан Завхан аймгийн Идэр сумын сургуулийн хуучин барилгыг сурагчдын дотуур байр болгон засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтад оролцогч “Их найман баганат” ХХКомпани гомдлыг Сангийн яаманд гаргасан бөгөөд Сангийн яамнаас уг ажлыг шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэр үндэслэлтэй, Завхан аймгийн Ургамал сумын 160 хүүхдийн хүүхдийн хичээлийн байр, спорт заалны барилгуудын засварын ажил, халаалтын тогооны барилгын ажилд оролцогч “Зэмбэт дөрвөлжин” ХХК-аас гомдлыг Сангийн яаманд гаргасан. Сангийн яамнаас гомдлыг хянаад Зэмбэт дөрвөлжин ХХК-ийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн жагсаалтад байх кран нь банкны өмчлөлд, туслан гүйцэтгэх гэрээнд гэрээгээр гүйцэтгэх ажлын төлбөр тусгагдаагүй зэрэг зөрчлүүд нь тус компанийн тендерээс татгалзах үндэслэл болно. Тендер шалгаруулалтад хамгийн сайн үнэлэгдсэн “Их найман баганат” ХХК-ны ирүүлсэн тендерт гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна гэсэн зөвлөмжийг ирүүлсэн.

4. Өоääëääì àààö àæëëääàààíü öýöýäæëëòëéí òàëààòö ä¿äíýëò, ñàìäë

Худалдан авах ажиллагааны алба нь 2017 онд зарлагдахаар төлөвлөгдсөн нийт тендер зарлагдсан бөгөөд худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага төлөвлөсөн ажлаа 100% хуулийн хүрээнд хэрэгжүүлсэн. Сангийн сайдын 2012 оны 264 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын МАЯГТ 1-ийн дагуу төлөвлөн баталж, МАЯГТ 2,3-ийн дагуу улирал бүр худалдан авалтын тайлан мэдээг цаг хугацаанд хүргүүлэн ажилласан.

2017 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад дараах хүндрэлүүд байлаа. Захиалагч байгууллагын хувьд:

- 2017 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний зураг төсвийг урьдчилан бэлтгээгүй.
- Бараа, ажил, үйлчилгээгээ хуулийн хүрээнд зөв төлөвлөж чадаагүй.
- Барааны техникийн тодорхойлолтыг шаардлагын хэмжээнд ирүүлдэггүй.

ХАА-ны мэргэжлийн байгууллагын хувьд

Хүндрэл:

- Шалгарсан гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл хянах, гэрээ байгуулах, ажил хүлээн авахад оролцох боломжгүй. /Аймгийн Засаг даргын захирамжинд ХАА-ны мэргэжлийн байгууллагаас төлөөлөл ороогүй/
- Сумдад шалгаруулсан тендерийг хянах боломжгүй /машин унааны шатахуун, томилолтын зардал огт төлөвлөгдөөгүй/

Гүйцэтгэгч байгууллагын тухайд:

- Тендерийн бичиг баримтын бүрдүүлэлт хангалтгүй.
- Санхүүгийн болоод хүн хүч, техникийн чадавхийн шаардлага хангаагүй байж тухайн ажлаа судлалгүй тендерт оролцдог.
- Хууль эрх зүйн мэдлэг сул
- Цахим тендер шалгаруулалтын тухай ойлголт мэдлэг хангалтгүй.

Төр, иргэний нийгэм, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөлийн тухайд

- Төрийн байгууллагыг төлөөлж буй үнэлгээний хорооны зарим гишүүд үнэлгээнд бүрэн хэмжээгээр оролцдоггүй.
- Иргэний нийгмийн байгууллага болон иргэний төлөөлөлөөс үнэлгээний хороонд оролцож буй хүний тоо хангалтгүй, аймгийн ИТХ-аас үнэлгээнд оролцуулах иргэний төлөөллийг нэмэгдүүлэх шаардлагатай.

5.Гэрээний хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилласан талаарх мэдээллийг тусгана

2017 онд хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ,ХОХБТХ, ГХБХБГазар, сумдын Засаг даргын Тамгын газар зэрэг захиалагч байгууллагууд гэрээ байгуулж хяналт тавин ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны алба гэрээний хэрэгжилтэд сумдад ажиллаж хяналт тавих боломж хомс байсан. Учир нь 2017 онд шатахуун, томилолтын зардал төсөвт тусгагдаагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн томилсон шийдвэрт албаны ажиллагсад ороогүй. /Гэрээнд гарын үсэг зурах, гүйцэтгэл хянах, ажил хүлээн авах/

6.Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг цаашид улам үр дүнтэй болгох санал, зөвлөмж, хүсэлтийг тусгаж өгнө.

Цаашид анхаарах асуудал

Захиалагч байгууллагын тухайд:

- Сум, байгууллагын дарга, эрхлэгч, худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтныг сургах, давтан сургах
- Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулах ажлын жагсаалт, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл зэргийг хуулийн хугацаанд ирүүлэх
- Худалдан авах барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний төсөв тооцоог хуулийн хүрээнд бэлтгэж ирүүлэх
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсвийн төлөвлөлттэй хамт авч ХАА-ны мэргэжлийн байгууллагад ирүүлдэггүй байдлыг зогсоох захиалагч байгууллага хуулиа дээдлэн хуулиа хэрэгжүүлж ажилладаг болох
- Худалдан авах ажлын баталгаажсан зураг төсөв, барааны техникийн тодорхойлолтыг шаардлагын хэмжээнд бэлтгэн хугацаа алдахгүй ирүүлэх

Гүйцэтгэгч байгууллагын тухайд:

- Санхүүгийн болоод хүн хүч, техникийн чадавхийг нэмэгдүүлэх
- Өөрийн хүчин чадалд тохирсон ажилд оролцох
- Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх
- Гэрээ байгуулсан ажлаа чанарын шаардлагын дагуу хийж гүйцэтгэх

Иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллага, иргэний тухайд:

- Иргэний нийгмийн байгууллагуудын худалдан авах ажиллагааны сүлжээг өргөтгөх, хүний тоог нэмэгдүүлэх
- Үнэлгээний хороонд орох иргэний төлөөллийг тоог нэмэгдүүлэх

Худалдан авах ажиллагааны албаны тухайд:

- Байгууллагын төсөв, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх
- Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
- Үнэлгээний хорооны гишүүдийг чадавхижуулах
- Цахим тендерийн төлбөр орон нутагт тухай бүр оруулдаг байх
- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагын эрхийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьдаг гэрээ байгуулахад оролцох, ажил хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орох, үнэлгээний хороог мэргэжлийн байгууллага өөрөө байгуулдаг болох
- Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагыг сумдад зохион байгуулсан ХАА-г хянах боломжоор хангах

Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн хүрээнд:

Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам"-ыг Сангийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тушаалар баталсан бөгөөд тус журмын 3.10-т заасны дагуу 2017 оны үнэлгээний хороонд орж ажилласан иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийн 11 хүнд ажилласан цагийг ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх 2,2 сая төгрөгийн урамшуулал олгосон.

Хянасан.....Д.Батмэнд

Боловсруулсан.....М.Өлзиймаа